

Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2016 оны 01 сарын мэдээ

2016 оны 01 дүгээр сарын 22

Судалгаа, шинжилгээ, байгалийн нөөц

Германы сэргээн босголтын банк / KFW /-ы хүрээнд хэрэгжиж буй БОЯБУАӨДЗ нь төсөлд Орхоны хөндийн БЦГ-ын менежментийн төлөвлөгөө, харьяа 6 сумын орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн оролцох хүсэлтээ илэрхийлж, төслийг товч тайланг хүргүүлээд байна.


Төсөлд хамран оролцогчоор НҮБ-ын байгаль орчны нэгж, Өвөрхангай, Архангай аймгуудын БОАЖАлбадууд, МУИС-ын Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль, Монголын аялал жуулчлалын Торгоны зам төслийн багуудыг сонгон холбогдох материалыг хүргүүлээд байна.

Биосан программд амьтан байгаль хамгаалагчдаас ирүүлсэн амьтан ажиглалтын 17 мэдээ байршуулсан.

Архангай аймгийн БОАЖГазарт ТХГН-ын ойн санд тархсан хортон устгал хийлгэх саналыг хүргүүлсэн.

БОНХАЖЯамнаас ирүүлсэн 2016.01.15 №09/289 албан тоотын дагуу ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй газар ашиглагчдын газрын татвар төлөлт, тэмдэгтийн хураамжийн төлбөр төлөөгүй аан, иргэдийн судалгааг орон нутгийн төр захиргааны байгууллага, татварын алба, ТХНУГ-тай хамтран гаргаж мэдээг хүргээд байна.

Мэдээлэл, сурталчилгаа



“ТХГН-ийн ойн цэвэрлэгээ” богино хэмжээний киног өөрсдийн нөөц бололцоог ашиглан цогцолборт газарт явуулсан ойн арга хэмжээний баримт материалд тулгуурлан “Movie editng” программ ашиглан хийж цахим мэдээллийн хэрэгсэлүүдэд байршуулан олон нийтийн хүртээл болгоод байна.

Хархорин суманд жил бүр уламжлал болгон

зохион байгуулдаг “Мөсний баяр”-ын арга хэмжээг сумын ЗДТГазар, ЭБЦТС-ТӨХК хамтран 1 сарын 23-нд хийлээ. Уг арга хэмжээнд 14 байгууллага аж ахуй нэгж 200 гаруй албан хаагч хамрагдан мөсний шагай харваа, буухиат чарганы уралдаан, олс таталт, тэшүүр гэсэн 4 төрлөөр уралдлаа. Хамгаалалтын захиргааны хамт олон уралдаан тэмцээнд амжилттай оролцон Тэргүүн байр эзлэн шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.



Өвөрхангай аймгийн Аудитын газарт 2015 оны санхүүгийн баримт материалыг шалгуулан зөрчилгүй дүгнүүлээ.

Хяналт шалгалт

Хархорин сумын Засаг дарга, Хамгаалалтын захиргааны дарга нарын хамтарсан ойн зөрчлөөс урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Хархорин сумын БОХ-ын Улсын байцаагч, байгаль хамгаалагч, цагдаагийн хэлтэстэй хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Хяналт шалгалтаар Хархорин сумын түлээний зах “Тэргэл нарны туяа”, Эрдэнэзуу худалдааны төвийн гадаа түлээний мод зарж байгаа 5-н иргэнийг шалган заавар зөвлөгөө өгч ажиллаа.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох.